

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд:

“VIII.ХЭЛЭЛЦСЭН нь: Польш Улсын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан 50 сая еврогийн нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн тухай хэлэлцээд дараах төслүүдийг санхүүжүүлэхээр тогтов:

1.1. Хөдөө аж ахуйн машин, трактор угсрах үйлдвэр байгуулах төсөл-32.0 сая евро;


1.2. Аймгийн төвүүдийн бохир ус, цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл-9.9 сая евро;

1.3. Авто замын байгууламжийн нэмэлт материалын үйлдвэр байгуулах төсөл-5.1 сая евро;

1.4. Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл-3.0 сая евро.

2. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх талаар Польшийн талтай тохиролцож холбогдох тусгайлсан зээлийн гэрээ байгуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд, төслийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд нарт даалгав.

3. Төслүүдийн холбогдох тусгайлсан зээлийн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Сангийн сайдад олгохоор тогтож Ерөнхий сайдын захирамжийг ажлын журмаар гаргахаар болов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР